



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/499


Улаанбаатар хот

Тушаал шинэчилж,
эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.3 дахь хэсэг, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2024 оны “Журам батлах тухай” 78 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2024 оны “Тэргүүлэх чиглэл, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай” А/347 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл (2024 он)”, 2024 оны “Төсвийн хуваарь шинэчлэн батлах тухай” А/493 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн дэмжих сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт”-д тусгагдсан Монгол Улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийг оношлох, эмчлэхэд шаардлагатай “Эмгэг судлалын лабораторын багаж, тоног төхөөрөмж худалдан авах төсөв”-ийг шинэчлэн нэгдүгээр, “Техникийн тодорхойлолт”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр худалдан авах багаж, тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг холбогдох эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт шилжүүлсүгэй.
3. Шаардагдах санхүүжилтийг Эрүүл мэндийг дэмжих сангийн (100900020061) төсвөөс шийдвэрлэхийг Санхүү, эдийн засгийн бодлогын газар (Э.Мөнхсүх)-т зөвшөөрсүгэй.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбоотойгоор Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/422 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН